



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

Мөнгөний бодлогын газар

2023.10.26



- Мөнгөний болон макро зохистой бодлогын хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд
- Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд
- Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд

1. Мөнгөний болон Макро зохистой бодлогын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2. Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоог бэхжүүлж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, нөхцөлүүдийг сайжруулна.





1.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

1.4. Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой оновчтой хослуулан хэрэгжүүлнэ.

1.5. Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоонд нийцтэй байдлаар Төв банкны олон нийттэй харилцах харилцааг боловсронгуй болгоно.


Зорилт 1.1

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд +/- 2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.




Эдийн засгийн өсөлт оны эхний хагаст 6.4 хувьтай гарав.

—○— Одоогийн төсөөлөл



	2022	2023*			2024*		2025*	
		төсөөлөл						
БДНБ өсөлт	5.0	5.6	6.0	5.9	[3.8-7.4]	[3.5-8.5]	[3.0-8.9]	
Уул уурхай	-15.3	23.9	8.9	21.6	[22.2-25.7]	[6.4-11.4]	[18.3-24.5]	
УУ-н бус	8.2	3.4	5.5	3.5	[1.7-5.2]	[3.0-8.0]	[0.6-6.4]	



Зорилт 1.2

Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоог бэхжүүлж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, нөхцөлүүдийг сайжруулна.

Инфляцыг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт бүрэн шилжих шаардлагатай нөхцөлүүд

- 1. Институционал бие даасан байдал.** Инфляцыг онилох мөнгөний бодлого хэрэгжүүлэхэд Төв банк зөвхөн ганц эцсийн зорилтыг хэрэгжүүлдэг, тэр нь хуулийн хүрээнд олон салаа утгагүй тодорхойлогдсон байх, харин бусад зорилтууд (ханшийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой өсөлт зэрэг) нь үндсэн зорилтын хавсарга зорилт болон тодорхойлогдож болдог.
- 2. Сайн хөгжүүлсэн шинжилгээний арга техник.** Инфляцыг онилох мөнгөний бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай гол орц бол инфляцын төсөөлөл байдаг. Монголбанк Мөнгөний бодлогын шийдвэр гаргахад “Төсөөлөл, бодлогын шинжилгээний систем”-ийг 2012 оноос эхлэн хөгжүүлж, шийдвэр гаргах процессыг тодорхой форматын дагуу цогц байдлаар улирал бүр тогтмол хийж байна.
- 3. Төсвийн бодлогын давамгайлал бус байдал.** Төсвийн бодлого давамгайлал буюу төсвийн зардал хэт өндөр, төсөв байнга алдагдалтай үед төв банкнаас үндсэн зорилт болох үнийн тогтвортой байдлыг хангахын тулд авч хэрэгжүүлж буй аливаа бодлогын үр дүн бага байдаг.
- 4. Гадаад тэнцлийн тогтвортой байдал.** Гадаад тэнцэл тогтвортой байх нь гадаад валютын жаахан дамжин инфляцын зорилтыг хангахад эерэг нөлөөтэй. Манай улсын хувьд төсөв болон худалдааны алдагдал тогтмол өндөр хадгалагдаж ирсэн нь эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж инфляцыг бага түвшинд тогтворжуулахад том хязгаарлалт болж байна.
- 5. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын хэлбэлзэл бага байх.** Мөнгөний бодлогын хэрэгслүүд нь дотоод эрэлтээр дамжин инфляцад нөлөөлдөг. Харин нийлүүлэлтийн талд нөлөөлөх боломжгүй (Жишээлбэл, тээвэр саатах, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалсан ургац буурах, мал хорогдох г.м). Иймд мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах боломжгүй инфляцын хэлбэлзлийг бууруулахад бусад бодлого боловсруулагчид чухал үүрэгтэй. Тухайлбал, улирлын шинжтэйгээр эсвэл түр хугацаанд барааны хомсдолоос шалтгаалсан үнийн өсөлт бий болохгүй байхад нийлүүлэлтийн гинжин хэлхээ, дэд бүтцийг сайжруулах шаардлагатай байна.

Инфляцыг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт бүрэн шилжих шаардлагатай үйл ажиллагаа

- Мөнгөний бодлогын шийдвэр гаргах процесс, түүнд шаардлагатай тооцоо судалгаа, загварууд, шинжилгээний чадварыг үргэлжлүүлэн сайжруулж, хүний нөөцийн чадварыг нэмэгдүүлэх, тасралтгүй байдлыг хангах
- Төсвийн бодлогыг өрийн тогтвортой байдлыг харгалзан мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлэх, зарцуулалтын оновчтой байдал, үр ашгийг нэмэгдүүлэх
- Төсвийн давамгайллын талаар судалгаа шинжилгээ хийх, авах шаардлагатай арга хэмжээг тодорхойлох
- Засгийн газрын үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх
- Төв банкны бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн орчныг судлах, шаардлагатай өөрчлөлтийг хийх
- Гадаад тэнцвэртэй байдлыг хангахын тулд эдийн засгийн бүтэц, төрөлжилтийг нэмэгдүүлэх, ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого баримтлах.
- Санхүүгийн захыг хөгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, түүнд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх институцын болон шинжилгээний тогтолцоог хөгжүүлэх



Зорилт 1.3


Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн уян хатан тогтох зарчмыг баримтална.

Үндэслэл

Бодлого




Ханш уян хатан тогтох
бодлого баримтлах



Эдийн засагт хурдан
тохиргоо хийгдэж, гадаад
шокд бага өртөх

Нөхцөл байдал



ГАДААД ШОКОНД
ӨРТӨМТГИЙ



Гадаад валютын нөөцийг
хадгалах

Шалтгаан

Хөрөнгийн урсгал чөлөөтэй
/Боломжгүйн гурвалжин/

Эрдэс бүтээгдэхүүний
орлогоос ЭЗ өндөр
хамааралтай

ЭЗ-ийн төрөлжилт багатай



Банк, санхүүгийн салбарт
тогтворгүй байдал үүсэх
эрсдэлтэй нөхцөлд валютын
зах зээлд оролцох

Үр дагавар

Анхаарах асуудал

Төлбөрийн тэнцэл оны эхний хагаст ашигтай байлаа...

Урсгал данс



✓ Нүүрсний экспорт түүхэн дээд түвшинд хүрч өслөө

✓ Импортын өсөлт, үнэ саарав.

Санхүүгийн данс



✓ ОТ-н хөрөнгө оруулалт ГШХО-ыг тодорхойлж байна


✓ МУХБ, хувийн секторын бондын төлбөрүүд хүлээгдэж байна

ГВАН




✓ Гадаад орчны тодорхой бус байдал өндөр хэвээр үед ГВАН-ыг нэмэгдүүлэх шаардлагатай

УРСГАЛ ДАНС




■ Экспорт ■ Импорт ■ Үйлчилгээ ■ Орлого — Урсгал данс

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



САНХҮҮГИЙН ДАНС




■ ГШХО ■ Бусад ХО ■ Санхүүгийн дансны тэнцэл ■ Багцын ХО ■ Санхүүгийн үүсмэл хэргэсэл




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Импортын өсөлт, үнэ эрчтэй саарч байна ...



- Түргэн эдэлгээтэй бараа
- Удаан эдэлгээтэй бараа
- Суудлын автомашин
- Аж үйлдвэрийн орц
- Барилгын материал
- Дизель түлш
- Бусад шатахуун
- ХО-н бүтээгдэхүүн
- Бусад
- Импортын өсөлт

Импортын үнийн жилийн өөрчлөлт, хувиар



- Хэрэглээний бүтээгдэхүүн
- Аж үйлдвэрлэлийн орц
- Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн
- Нефтьийн бүтээгдэхүүн
- Бусад
- Импортын үнийн жилийн өөрчлөлт



Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Монголбанк жолоодлогогүй ханшийн хэлбэлзэл зах зээлд үүсэж улмаар санхүүгийн тогтвортой байдал алдагдахаас сэргийлэх, гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй ханшийн богино хугацааны огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор тухай бүр захад оролцоно. Уян хатан валютын ханшийн бодлогын хүрээнд гадаад валютын захын үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс (i) валют арилжааны цахим талбараар, (ii) шаардлагатай тохиолдолд дуудлага худалдаа хийх хэлбэрээр валютын захад оролцоно.
- Гадаад валютын улсын нөөцийн хүрэлцээт байдлыг тогтвортой хадгалах, нийт нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод эх үүсвэр татах ажлыг зохион байгуулна.
- Валютын захын оролцогчдын хүлээж буй ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зорилт 1.4


Макро-санхүүгийн харилцан нөлөөг харгалзан, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой оновчтой хослуулан хэрэгжүүлнэ.

Зээлийн өсөлт 9 дүгээр сард 13.7 хувьд хүрлээ.



Үндэслэл


- Эдийн засагт сөрөг шокууд зэрэг тулгарсан үед макро эдийн засгийн уналтаас сэргийлэх, тогтворжуулах нь **бодлогын сорилт болж байна.**
- Гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалан бодит эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн уналтууд давхцаж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэн, **банк, санхүү, бодит эдийн засгийн хүндрэл үүсэх эрсдэл хэвээр байна.**
- Макро эдийн засгийн болон санхүүгийн бодлогуудыг хослуулан ашиглах буюу **макро цогц бодлого (МЦБ)-ыг хэрэгжүүлэх шаардлагатай.**
- **Макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлснээр** мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдан бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ.




Санхүүгийн системийн эрсдэлийн зураглал

- 2022 оны эхэнд дэлхий дахинаа тодорхой бус байдал нэмэгдэж, эдийн засгийн сэргэлт удааширсны зэрэгцээ БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан хилийн боомтуудын үйл ажиллагаа доголдсоноор Монгол Улсын гадаад сектор, макро эдийн засаг, мөнгөний зах зээл, банкны секторын эрсдэл нэмэгдэж, **санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексийн утга өссөн.**
- Харин 2022 оны дунд үеэс хилийн хязгаарлалт суларч голлох уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил сэргэж эхэлсний зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах, инфляцыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний нөлөөгөөр дээрх эрсдэлүүд 2022 оны туршид улам бүр багасаж, **санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексийн утга харьцангуй бага түвшинд хүрээд байна.**

Санхүүгийн системийн нэгдсэн индекс



Системийн эрсдэлийн зураглал




Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Макро-Санхүүгийн бодлогуудын арга хэрэгслүүдийн үр нөлөө, харилцан хамаарлыг тодорхойлох шинжилгээний арга зүйг хөгжүүлнэ.
- Макро-Санхүүгийн хамаарлын шинжилгээг хийж эхлэн бодлогын шийдвэр гаргалтад ашиглаж эхэлнэ.
- Санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ арга аргачлалыг хөгжүүлж, бодлогын шийдвэр гаргалтад нэвтрүүлж эхэлнэ.
- Санхүүгийн системд үүсэж буй эрсдэлүүдийн тогтмол хянаж, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэгдсэн макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.



Зорилт 1.5

Инфляцыг онилох мөнгөний бодлогын тогтолцоонд нийцтэй байдлаар Төв банкны олон нийттэй харилцах харилцааг боловсронгуй болгоно.



- Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь мөнгөний бодлогын хүрээ (monetary policy framework)-ний нэг чухал бүрэлдэхүүн бөгөөд үр дүнтэй мөнгөний бодлогын тулгуур болдог.
- Иймд Монголбанк олон нийттэй харилцах үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор дотоод үйл ажиллагаандаа тасралтгүй шинэчлэлт хийхийн зэрэгцээ олон улсын сайн туршлагуудыг судалж, нэвтрүүлсээр ирсэн.
- Цаашид инфляцыг онилох мөнгөний бодлогын дэглэм (inflation targeting regime)-ийг хэрэгжүүлэхэд хэрэгтэй олон нийттэй харилцах мөчлөг, мэдээллийн агуулга шаардлагатайгаас гадна Төв банкны оролцогч талууд (stakeholder)-д тохирсон олон тал сувгаар мэдээллийг түгээх нь зах зээлийн хүлээлтийг удирдахад илүү үр дүнтэй юм.
- Монголбанк нь 2023 онд олон улсад Төв банкны мөнгөний бодлогын хүрээг үнэлдэг IАРОС индексээр 0.63-т эрэмбэлэгдэж байгаа нь хөгжиж буй орнуудын дундаж (0.57)-аас өндөр ч хөгжсөн орнуудын дундаж (0.71)-ээс бага байгаа тул цаашид сайжруулах шаардлагатай байна.
- Тус индексийн нэг үндсэн бүрэлдэхүүн болох олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулах нь инфляцыг онилох мөнгөний бодлогыг амжилттай хэрэгжүүлж, эдийн засагт үнийн түвшний тогтвортой байдлыг хангах нэг нөхцөл болно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ



Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд үнэлгээ хийж, шаардлагатай сайжруулалтуудыг хийнэ;
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаа, дотоод мэдээллийн урсгалыг оновчтой болгох бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийнэ;
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулах бодлогын баримт бичгүүдийг шинэчилнэ;
- ОУВС-гийн техник тусламжийн хүрээнд өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ;
- IАРОС индексийг сайжруулах өөрчлөлт, шинэчлэлтүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ;
- Инфляцыг онилох мөнгөний бодлогын элементүүдийг олон нийттэй харилцах харилцаанд нэвтрүүлнэ;
- Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлын зохион байгуулалтыг сайжруулна;
- Статистик мэдээллүүдийг хуваарийн дагуу олон нийтэд олон талт хэлбэрээр түгээнэ;
- Орон нутагт мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлнэ;
- Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын эдийн засгийн мэдлэг боловсролыг сайжруулах, Төв банкны бодлого, үйл ажиллагааны талаарх ойлголтыг дээшлүүлэх уулзалт, сургалтын зохион байгуулалтын арга хэлбэрийг өөрчилж, тогтмолжуулна;
- Эдийн засгийн оролцогчдын онцлогт тохирсон мэдээллийн сувгуудыг хөгжүүлж, контент боловсруулж түгээнэ;
- Олон улсын байгууллагуудтай хамтран Төв банкны олон нийттэй харилцах харилцааг олон улсын сайн жишигт суурилуулан нэвтрүүлнэ;

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангана.

2.2. Банкуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн цдирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох эрсдэлүүдийг дотооддоо үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.


2.3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Зорилт 2.1

Гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангана.

Үндэслэл

Гадаадын банк үйл ажиллагаагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж эхэллээ.



Гадаадын банкны салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны журам

МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөлөл

- Банкны салбар дахь өрсөлдөөнийг эрчимжүүлнэ.
- Инновац, шинэ технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
- Зээлийн шинэ эх үүсвэр нэмэгдэж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Банкны засаглал, хянан шалгалтын чадавхыг бэхжүүлэхэд эергээр нөлөөлнө.
- Корреспондент төлбөр тооцоо болон худалдааны санхүүжилтийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.



Хэрэгжүүлэх арга хэмжээ

Гадаадын банкны салбар, нэгж үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд:

- Гадаадын банкны салбар, нэгж үйл ажиллагаагаа явуулахад тавигдах нөхцөл шаардлагыг гадаадын банкны харьяалал, өмчлөлийн төрөл, бизнес загварт нь тохируулан нарийвчлан тогтоож, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, журамд өөрчлөлт оруулах;
- Монгол Улсад салбар, нэгжээ байгуулах хүсэлтэй гадаадын банкны улс орны хянан шалгах эрх бүхий этгээдтэй Монголбанк хамтын ажиллагааны гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах замаар мэдээлэл солилцох, хамтарсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг бий болгох хүрээнд:

- Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл олгох, үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, хязгаарлалт зохистой харьцаа, хяналт шалгалттай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тодорхойлж, холбогдох журмуудыг боловсруулан, батлуулах



Зорилт 2.2

Банкуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн цдирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох эрсдэлүүдийг дотооддоо үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 2.2

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үнэлгээний цогц аргачлалыг нэвтрүүлэн банк дотооддоо эрсдэлээ үнэлэх тогтолцоог бүрдүүлэх замаар банкны зохистой засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулна.

Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд үнэлэх үндсэн хэсгүүд

1. Бизнес загвар	2. Засаглал ба эрсдэлийн удирдлага	3. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл	4. Хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэл
<ul style="list-style-type: none">• Бизнес загварыг үнэлэх	<ul style="list-style-type: none">• Зохистой засаглалыг үнэлэх;• Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх.	<ul style="list-style-type: none">• Зээл, зах зээл, үйл ажиллагаа болон хүүгийн (IRRBB) эрсдэлүүдийг үнэлэх;• Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг үнэлэх;• Стресс тест хийх.	<ul style="list-style-type: none">• Богино хугацааны хөрвөх чадварын эрсдэл болон тогтвортой санхүүжилтийн эрсдэлийг үнэлэх;• Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг үнэлэх;• Стресс тест хийх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ



Базел стандартын Бүлэг 2-т заасны дагуу банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ (ICAAP), хөрвөх чадварын хүрэлцээ (ILAAP)-г дотооддоо үнэлэх аргачлалыг холбогдох журам, зөвлөмжид тусгаж, **банкны системд үзүүлэх нөлөө, эрх зүйн орчин** зэрэгтэй уялдуулан холбогдох хугацаат төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хэрэгжүүлэх.



Банкуудын хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-ыг Базел стандартын **хөрвөх чадварын зохистой харьцааг** нэвтрүүлэх хугацаатай уялдуулан хэрэгжүүлэх.




Хяналт шалгалтын үнэлгээний аргачлалыг (SREP) нэвтрүүлэх зорилгоор холбогдох журам, зөвлөмжийг шинэчилж, банкны хянан шалгагч нарыг эрчимжүүлсэн сургалтад хамруулж, чадавхжуулах.



Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ын хүрээнд макро стресс тест, банкуудын богино бөгөөд дунд хугацааны бизнес загварын үнэлгээг гүйцэтгэх.

Зорилт 2.3

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.




Хэрэгжүүлэх арга хэмжээ

Үндэсний болон салбарын эрсдэл, стратегийн шинжтэй аюул занал, чиг хандлага, типологийг тогтмол хянаж, өөрчлөлтийг үнэлэх

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боловсон хүчний чадавхыг бэхжүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дотоод болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх



Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэн, мэдээлэх үүрэгтэй этгээдийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чанаржуулах

Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлж буй болон хууль сахиулах байгууллагад шилжүүлж буй тайлан, мэдээллийн тоо, чанар, үр дүнтэй байдлыг сайжруулах арга хэмжээ авах

Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Хил дамнасан худалдааны цахим төлбөр тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.2. Их өгөгдлийн хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн хөгжлийг дэмжин ажиллана.

3.3. Олон нийтийн санхүү, эдийн засгийн талаарх боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.

3.4. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлж, зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Зорилт 3.1

Хил дамнасан худалдааны цахим төлбөр тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжиж, төлбөрийн системийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

- Зах зээлд төлбөр тооцооны шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэж, **бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ** нэмэгдэх хэрээр түүний зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна.
 - **Төлбөрийн картаар хийж буй гүйлгээний тоо** 2021 онд 7.7 сая ширхэг байсан бол 2023 онд энэ тоо нэмэгдэж 13.7 сая ширхэг болж өссөн байна (**1.8 дахин ↑**).
 - Гар утсаар хийгдэж буй **бэлэн бус шилжүүлгийн тоо** 2020 онтой харьцуулахад **4 дахин**, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын гаргасан цахим мөнгөний нийт хэмжээ **2.7 дахин** өссөн.
- Бүс нутагт үүссэн геополитикийн хурцадмал байдал, түүнээс улбаатай санхүүгийн хязгаарлалтууд нь Монгол Улсын **хил дамнасан гадаад худалдааны төлбөр тооцоонд** сөргөөр нөлөөлж, төлбөр тооцоо хурдан шуурхай, найдвартай хийгдэхэд саад бэрхшээл үүсгэж байна.
- Технолигид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ


- Төлбөрийн системийн оролцогчдын иж бүрэн хяналтыг хэрэгжүүлнэ,
- Төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаална,
- Төлбөрийн системийн оролцогч, хэрэглэгчээс ирүүлсэн санал, гомдлын дагуу холбогдох шалгалтыг хийж, шийдвэрлэнэ,
- Төлбөрийн системийн тоон үзүүлэлтийн тайлан гаргана,
- Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх замаар шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжинэ.



Зорилт 3.2

Их өгөгдлийн хүрээнд ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн хөгжлийг дэмжин ажиллана.

Ногоон зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр



- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах хүрээнд өнгөрсөн онд баталсан “**Үндэсний Замын Зураг**”-т ногоон зээлийн багцын хэмжээг **2030 он** гэхэд банкны салбарт **10 хувьд**, банк бус санхүүгийн салбарт **5 хувьд** хүргэх зорилгыг тодорхойлж, шаардлагатай дэд бүтэц, бодлогын зохицуулалтыг хийхээр тусгасан.
- Ногоон, тогтвортой бизнесийг дэмжих татварын таатай орчин бүрдүүлэх,
- Монгол улсад ногоон зээлийг таних, хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх

Стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

Стратеги:

- Банкууд, ТоС, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран Төв банк дээрх их өгөгдлийн суурь дэд бүтцийг ашиглан ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- **ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн** хэрэгжилтийг санхүүгийн салбарт туршиж, шаардлагатай нэмэлт өөрчлөлт, сайжруулалтыг хийх, шинэчилсэн таксономийн дагуу зээлийн статистик мэдээллийг салбарын хэмжээнд цуглуулах.
- ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн дагуу олгогдсон зээлийн үр нөлөөг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийн суурь шаардлага, мэдээлэл цуглуулах процесс, эх сурвалжуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэн, холбогдох талуудтай хамтран ажиллах.
- ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг санхүүгийн салбар, олон нийтэд таниулах мэдээлэл, сургалтын арга хэмжээ зохион байгуулах.

Зорилт 3.3

Олон нийтийн санхүү, эдийн засгийн талаарх боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлнэ.

Үндэслэл

- Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ болон бүтээгдэхүүний төрөл олширч, дижитал хэлбэрт шилжиж байгаа нь залуу үед илүү хялбар байгаа бол хүн амын бусад хэсэгт хэрэглэхэд төвөгтэй, санхүүгийн суурь мэдлэгийг эдгээрт нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна.
- Сүүлийн жилүүдэд банкны хувьцаа эзэмшигчдийн өмчлөх эрх, үүргийн талаарх мэдлэг, иргэдийг болзошгүй санхүүгийн болон дижитал эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн мэдлэг, мэдээллийг хүргэх шаардлага нэмэгдэж байна.
- Монголбанкнаас мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг дээшлүүлэх зорилгоор төв банкны тухай болон эдийн засаг, санхүүгийн суурь мэдлэгийг иргэд, олон нийтэд олгох ажлыг үргэлжлүүлэх шаардлага хэвээр байна.



Стратеги, хэрэгжүүлэх арга хэмжээ

Стратеги:

- Олон нийтийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын баримт бичгийг боловсруулан санхүүгийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Тодорхойлж хэрэгжүүлэх:

- Сургалт, мэдээллийн үндсэн агуулгыг боловсруулах
- Зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, мэдээллийн арга хэлбэрийг оновчтой тодорхойлох
- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг төрийн болон холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
- Өрхийн төсвийг цахимаар хөтлөх зорилго бүхий “Төсөвчин” аппликейшнийг шинэчлэх

Зорилт 3.4

Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлж, зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

1

Гүйцэтгэсэн ажил

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн:



**Монголбанк
Санхүүгийн зохицуулах
хороо хамтран**

1. Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд доорх зохицуулалтыг хүрээнд боловсруулсан

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах **нийтлэг шаардлагыг** тогтоож,
- Зохицуулагч байгууллагаас** зохистой хяналт шалгалт болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах **хяналт шалгалтыг** хэрэгжүүлэх,
- Олон нийтийн санхүүгийн **мэдлэгийг дээшлүүлэх.**

2. 2022.09.19-ний өдрийн А-1/990 дугаартай албан бичгээр Хууль санаачлагчид уламжилсан.



2

Гүйцэтгэж буй ажил

Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-202 тушаалаар байгуулсан.

Одоогийн нөхцөл байдал

1. Ажлын хэсгээс хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын **урьдчилсан тандан судалгааг** боловсруулсан,
2. 2023 онд багтаан Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд хуулийн **төслийг боловсруулах** ажлыг хийж гүйцэтгэхээр зорьж байна.

3

Гүйцэтгэхээр төлөвлөж буй ажил

Зээлийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад доорх зохицуулалтыг тусгахаар зорьж байна:

i

- Нууцлалын байдлыг цогцоор нь шийдвэрлэх
- Зээлийн мэдээллийн санд ямар тохиолдолд өөрчлөлт оруулах
- Зээлийн түүхийг зээлдэгчид харуулах хугацааг тодруулах
- Хил дамнасан байдлаар солилцох боломжоор хангах,
- Зээлдэгчийн эрсдэлийг оновчтой тооцоолж буй эсэхийг тодорхойлох,
- Цаашид зээлийн мэдээллийн үйл ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх зохицуулалт



**Анхаарал хандуулсанд
баярлалаа.**